“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 дугаар сарын 29-ний өдөр № 26/44 Улаанбаатар хот

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Эрсдэл ба Байгаль орчин, нийгэм, засаглалын удирдлагын хорооны 2026 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн ЭУХ-26/01 тоот дүгнэлт болон ТУЗ-ийн 2026 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ын зорилгод нийцүүлэн, Компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэнэ бүтээх, олон улсын стандартыг нэвтрүүлэх зорилтын хүрээнд Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого”-ыг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр шинэчлэн батлуулсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэгдэн батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн бодлого”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, дагаж мөрдөхийг Компанийн нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан бодлоготой холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ-д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Уганбаяр)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА О.БОЛДБААТАР